



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Шил” ажиллагааны хэрэгжилтийг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан авлигатай тэмцэх таван үйл ажиллагааны “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас ДААЛГАХ нь:

1. Доор дурдсан мэдээллийг нэгтгэж, машин унших форматаар бэлтгэн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэгтгэн хүргүүлэхийг дараахь албан тушаалтнуудад тус тус даалгасугай:

1.1. Тусгай хамгаалалттай газар нутагт олгосон газар ашиглах зөвшөөрөл, гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал, 2008 оноос хойш хийгдсэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний талаарх тайлан, мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ;

1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008 оноос хойш гарсан дүгнэлтийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн;

1.3. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

1.4. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт хүргүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд;

1.5. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

1.6. Зарласан тендер шалгаруулалтад шалгарсан болон шалгараагүй оролцогч, тэдгээрийн шалгарсан болон шалгараагүй үндэслэлийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт;

1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгож,


0023800002

тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.

2. Албан даалгаврын 1-д заасан мэдээллийг нэгтгэн “Шилэн индекс” гаргаж, дүнг Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.

3. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг хагас жилээр үнэлж, албан даалгаврыг биелүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Д.ОЮУН-ЭРДЭНЭ